



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 8/340

Мандалговь

Г

Т

Орчны бохирдлыг бууруулах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. "Хоггүй, цэвэрхэн Монгол" аяны хүрээнд нийтийн эзэмшилийн талбайд "Бүх нийтийн их цэвэрлэгээ-2019" арга хэмжээг удирдамж гаргаж байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр хамруулан 10 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулж, тайлагнахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Захирамжийг хэрэгжүүлэх явцад мэргэжил арга зүйгээр хангаж, олон нийтэд мэдээллийг хүргэж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Гантулга)-т даалгасугай.

Гурав. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ж.МӨНХЧУЛУУН



438190972